

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Хөгжим бүжгийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ЗАА-2022/91/СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежерийн үүргийг

түр орлон гүйцэтгэгч : Г.Заяа

Утас:92038288

Цахим хаяг: [zayag@audit.gov.mn](mailto:zayag@audit.gov.mn)

Интер аудит ХХК

Гэрээт аудитор: Г.Алтанцэцэг

Утас: 99469299, 90111091

Цахим хаяг: [altan\\_fin@yahoo.com](mailto:altan_fin@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.6.1 Төсвийн төлөвлөлт .....	14
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	14
3.6.3 Нэмэлт төсөв .....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй .....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит.....	15
4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит .....	15
4.2.1 Залруулсан алдаа.....	15
4.2.2 Төлбөрийн акт.....	15
4.2.3 Албан шаардлага .....	15
4.2.4 Зөвлөмж .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## 1.Аудитын санал дүгнэлт

  
**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
81000 Улнастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12

2022.02.21 № 1302/96

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨГЖИМ БҮЖГИЙН КОЛЛЕЖ  
ЗАХИРАЛ Ж.ГАНХУЯГ ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжим бүжгийн коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөгжим бүжгийн коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

013020076

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>216,586.75</u></b>	<b><u>490,935.25</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	11,234.32	142,769.05
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	265.27	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	62,970.72
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	10,969.05	79,798.33
3351	Байгууллагаас авах авлага	-	69,129.28
3352	Хувь хүмүүсээс авах авлага	10,969.05	10,669.05
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	205,352.43	348,166.20
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	68,097.36	213,619.07
35110	Тусгай зориулалттай материал	65,496.46	213,234.07
35130	Эм боох материал	2,600.90	385.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	137,255.08	134,547.13
35410	Бичиг хэргийн материал	2,570.75	2,760.75
35420	Аж ахуйн материал	124,764.58	123,365.38
35430	Сэлбэг хэрэгсэл	1,597.00	1,597.00
35450	Барилгын засварын материал	-	331.00
35460	Хүнсний материал	1,829.75	-
35470	Бусад хангамжийн материал	6,493.00	6,493.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,295,620.93</u></b>	<b><u>2,185,678.86</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,295,620.93	2,185,678.86
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,247,940.93	2,137,998.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,135,624.63	2,135,624.63
39202	Хуримтлагдсан элэгдэл	(128,416.90)	(189,521.14)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,500.00	23,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(23,500.00)	(23,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	325,811.39	330,605.39
39206	Хуримтлагдсан элэгдэл	(196,023.98)	(232,901.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	162,823.76	162,983.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	(103,523.29)	(121,663.98)
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,500.00	8,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,612.50)	(4,462.50)
39217	Ном	46,757.82	48,834.32
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	47,680.00	47,680.00
39301	Програм хангамж	2,150.00	2,150.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,150.00)	(2,150.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	47,680.00	47,680.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II</b>	<b><u>2,512,207.68</u></b>	<b><u>2,676,614.10</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>7,397.01</u></b>	<b><u>7,397.01</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	7,397.01	7,397.01
<b>413</b>	<b>Өглөг</b>	7,397.01	7,397.01
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	7,397.01	7,397.01
41361	Байгууллагад төлөх өглөг	7,397.01	7,397.01

<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,504,810.66</u></b>	<b><u>2,669,217.09</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,504,810.66	2,669,217.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,975,612.14	1,975,612.14
51101	Өмч: - төрийн	1,975,612.14	1,975,612.14
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(270,415.95)	(106,009.52)
51210	Өмнөх үеийн үр дүн	(270,415.95)	(270,415.95)
51220	Тайлант үеийн үр дүн	-	164,406.43
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	799,614.47	799,614.47
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,512,207.68</u></b>	<b><u>2,676,614.10</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,335,029.05</b>	<b>1,956,715.23</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>9,593.85</b>	<b>79,466.37</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	9,593.85	79,466.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,593.85	79,466.37
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,007.50	50,881.97
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,586.35	-
120009	Бусад орлого	-	22,735.84
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө/	-	996.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Бараа материал/	-	4,852.06
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,325,435.20</b>	<b>1,877,248.86</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,322,635.20	1,602,777.10
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,322,635.20	1,602,777.10
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	2,800.00	274,471.76
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	274,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,800.00	122.26
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	349.50
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,056,291.26</b>	<b>1,792,308.80</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,056,291.26</b>	<b>1,792,308.80</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	956,384.26	1,477,012.10
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	680,921.08	931,265.29
210101	Үндсэн цалин	593,397.65	678,490.94
210102	Нэмэгдэл	-	183,256.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,050.00
210104	Урамшуулал	87,523.43	66,467.62
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	37,455.40	133,008.14
210201	Тэтгэврийн даатгал	20,189.19	82,671.52

**Завхан аймгийн Хөгжим бүжгийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210202	Тэтгэмжийн даатгал	2,254.99	17,673.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,803.99	11,087.86
210204	Ажилгүйдлийн даатгал	615.53	3,594.86
210205	Эрүүл мэндийн даатгал	12,591.70	17,979.95
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>97,352.63</b>	<b>171,662.88</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,402.94	6,625.35
210302	Түлш, халаалт	87,912.00	156,288.00
210303	Цэвэр, бохир ус	4,037.69	8,749.53
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,934.96</b>	<b>15,417.14</b>
210401	Бичиг хэрэг	734.10	982.00
210402	Тээвэр, шатахуун	784.90	1,501.71
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,242.73	1,825.81
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,173.24	3,889.97
210408	Бараа материал акталсны зардал	-	7,217.65
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>20,946.83</b>	<b>37,205.91</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	2,215.90
210502	Хоол, хүнс	20,846.83	34,990.01
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,505.80</b>	<b>20,181.53</b>
210604	Урсгал засвар	1,505.80	20,181.53
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,960.50</b>	<b>8,790.70</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,952.50	7,290.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008.00	1,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>108,307.06</b>	<b>159,480.51</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	681.75	7,016.45
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,829.80	35,491.49
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	79,795.51	116,972.57
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>99,907.00</b>	<b>315,296.70</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>99,907.00</b>	<b>80,571.10</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	650.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	28,321.80
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	99,907.00	51,599.30
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>234,725.60</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	234,725.60
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>278,737.79</u></b>	<b><u>164,406.43</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>278,737.79</u></b>	<b><u>164,406.43</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,927,932.14	345,632.02	(183,552.67)	2,090,011.49
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>1,927,932.14</b>	<b>345,632.02</b>	<b>(183,552.67)</b>	2,090,011.49
C07	Тайлант үеийн үр дүн	47,680.00	-	(22,393.59)	25,286.41
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>1,975,612.14</b>	<b>799,614.47</b>	<b>(270,415.95)</b>	2,504,810.66
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>1,975,612.14</b>	<b>799,614.47</b>	<b>(270,415.95)</b>	2,504,810.66
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>1,975,612.14</b>	<b>799,614.47</b>	<b>(270,415.95)</b>	2,504,810.66
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	164,406.43	164,406.43
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>1,975,612.14</b>	<b>799,614.47</b>	<b>(106,009.52)</b>	2,669,217.09

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b><u>1,811,638.63</u></b>	<b><u>1,928,430.83</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,995.50</b>	<b>51,181.97</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	6,995.50	51,181.97
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	6,995.50	51,181.97
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,995.50	50,881.97
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,804,643.13</b>	<b>1,877,248.86</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,762,129.80	1,602,777.10
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,762,129.80	1,602,777.10
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	42,513.33	274,471.76
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	274,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,234.00	122.26
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	38,279.33	349.50
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,798,677.65</u></b>	<b><u>1,922,396.83</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,798,677.65</b>	<b>1,922,396.83</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,335,507.90</b>	<b>1,544,129.41</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	962,319.64	931,000.02
210101	Үндсэн цалин	601,984.46	677,614.81
210102	Нэмэгдэл	224,733.56	183,867.60

210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,835.02	3,050.00
210104	Урамшуулал	121,766.61	66,467.62
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>57,830.04</b>	<b>110,272.31</b>
210201	Тэтгэврийн даатгал	35,340.84	73,577.19
210202	Тэтгэмжийн даатгал	3,463.60	9,489.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,771.30	7,450.12
210204	Ажилгүйдлийн даатгал	692.40	1,776.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,561.90	17,979.95
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>164,226.66</b>	<b>171,662.88</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,167.89	6,600.35
210302	Түлш, халаалт	146,520.00	156,288.00
210303	Цэвэр, бохир ус	10,538.77	8,774.53
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,651.91</b>	<b>8,083.49</b>
210401	Бичиг хэрэг	901.60	734.00
210402	Тээвэр, шатахуун	2,295.70	1,501.71
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,881.13	1,825.81
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,573.49	4,021.97
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>54,573.14</b>	<b>37,645.76</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,199.90	-
210502	Хоол, хүнс	42,872.74	33,160.26
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,500.50	4,485.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,886.80</b>	<b>89,641.81</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	69,129.28
210604	Урсгал засвар	13,886.80	20,512.53
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>511.60</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	511.60	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,784.10</b>	<b>9,040.70</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,776.10	7,540.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008.00	1,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>61,724.01</b>	<b>186,782.44</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,896.57	10,347.95
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	54,827.44	176,434.49
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>463,169.75</b>	<b>378,267.42</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>104,927.00</b>	<b>80,571.10</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,020.00	650.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	28,321.80
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	99,907.00	51,599.30
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>358,242.75</b>	<b>297,696.32</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	358,242.75	297,696.32
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГА АНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>12,960.98</u></b>	<b><u>6,034.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>12,960.98</u></b>	<b><u>6,034.00</u></b>

22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>12,960.98</b>	<b>6,034.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	12,960.98	6,034.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,960.98	6,034.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(12,960.98)</u></b>	<b><u>(6,034.00)</u></b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,609,085.00	1,419,233.73
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,609,085.00	1,419,233.73
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,528,507.70	1,338,662.63
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,016,558.80	931,000.02
210101	Үндсэн цалин	710,291.50	677,614.81
210102	Нэмэгдэл	201,460.60	183,867.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,695.70	3,050.00
210104	Урамшуулал	102,111.00	66,467.62
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	135,834.90	110,272.31
210201	Тэтгэврийн даатгал	95,587.50	73,577.19
210202	Тэтгэмжийн даатгал	10,061.80	9,489.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,049.50	7,450.12
210204	Ажилгүйдлийн даатгал	2,012.40	1,776.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,123.70	17,979.95
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	220,489.80	171,662.88
210301	Гэрэл, цахилгаан	17,625.60	6,600.35
210302	Түлш, халаалт	185,840.60	156,288.00
210303	Цэвэр, бохир ус	17,023.60	8,774.53
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,463.80	7,961.49
210401	Бичиг хэрэг	815.00	612.00
210402	Тээвэр, шатахуун	1,981.80	1,501.71
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,578.20	1,825.81
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,088.80	4,021.97
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	64,643.50	37,570.26
210502	Хоол, хүнс	60,156.80	33,084.76
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,486.70	4,485.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	25,513.80	25,466.53
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000.00	4,954.00
210604	Урсгал засвар	20,513.80	20,512.53
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,914.70	9,040.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,914.70	7,540.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000.00	1,500.00

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	46,088.40	45,688.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,511.20	10,147.95
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	35,577.20	35,540.49
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	80,577.30	80,571.10
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	80,577.30	80,571.10
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	656.00	650.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,321.80	28,321.80
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	51,599.50	51,599.30
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,609,085.00	1,419,233.73
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,602,777.10	1,368,351.75
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,602,777.10	1,368,351.75
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	6,307.90	50,881.97
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,307.90	50,881.97
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	0.075	0.075
620001	Удирдах ажилтан	0.002	0.002
620002	Гүйцэтгэх ажилтан	0.046	0.046
620003	Үйлчлэх ажилтан	0.027	0.027

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>211,500.78</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>211,500.78</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	211,500.78
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	122.00
210401	Бичиг хэрэг	122.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	75.50
210502	Хоол, хүнс	75.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	69,129.28
210601	Багаж, техник, хэрэгсэл	69,129.28
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	142,174.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	141,974.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	211,500.78
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	211,500.78
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	211,029.02
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	122.26
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	349.50

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Завхан аймгийн Хөгжим бүжгийн коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Алтанцэцэг, Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Хөгжим бүжгийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн №1/09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Завхан аймгийн Хөгжим бүжгийн коллеж нь үйл ажиллагааг оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлэх, төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, сонирхлын зөрчилгүй ажиллах, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, төсвийн болон эд хөрөнгийг зохистой ашиглах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зэрэг манлайллын зорилтуудыг ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь дээд байгууллагаас гаргасан системийн хэмжээнд дагаж мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэдэг, дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулан мөрддөггүй.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглаж, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Хөгжим бүжгийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 1,609.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 16.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлыг 70 хувь буюу 11.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	11,234.32	142,769.05	131,534.73
Бараа материал	205,352.43	348,166.20	142,813.76
Үндсэн хөрөнгө	2,295,620.93	2,185,678.86	(109,942.07)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,512,207.68</b>	<b>2,676,614.10</b>	<b>164,406.43</b>
Өр төлбөр	7,397.01	7,397.01	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,504,810.66	2,669,217.09	164,406.43
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,512,207.68</b>	<b>2,676,614.10</b>	<b>164,406.43</b>

Авлага дансны үлдэгдэл 131.5 сая төгрөгөөр өссөн 2020-2022 онд хэрэгжих гэрээтэй Швейцарын төслийн чиглэлийн авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 142.8 сая төгрөгөөр өссөн нь худалдан авсан 233.5 сая төгрөгийн бараа материалаар нэмэгдэж, 83.5 сая төгрөгийн бараа материал зарцуулан, 7.2 сая төгрөгийн бараа материал акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 109.9 сая төгрөгөөр буурсан нь 7.0 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн 116.9 сая төгрөгийн элэгдлийн зардал хасагдсантай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 164.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,602.8 сая төгрөг, өөрийн орлогоор 6.3 сая төгрөгийг, нийт зарлагыг 1,609.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,602.7 сая төгрөг, өөрийн орлогоор 51.1 сая төгрөг, нийт 1,653.8 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,419.2 сая төгрөгийг зарцуулж 234.6 сая төгрөг буцаан төвлөрүүлсэн байна

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн гүйцэтгэлээр Швейцарын төслийн санхүүжилтээр 274.0 сая төгрөг, дээд шатны захирагчаас 0.12 сая төгрөг, өөрийн орлогоос 0.35 сая төгрөг, нийт 274.5 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардлаар бараа, үйлчилгээний зардалд 211.5 сая төгрөгийг зарцуулж 63.0 сая төгрөг буцаан төвлөрүүлсэн байна

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Дээд шатны байгууллагын шийдвэрээр 6.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаагүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

#### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих нийт 147 мэдээ байршуулахаас 4 мэдээ хугацаа хоцроож, хөрөнгө оруулалт, тендерийн 5 саяас дээш үнийн дүнтэй мэдээг буруу мэдээлсэн.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 3.45 сая төгрөгийн төлбөрийн актыг барагдуулсан, 2 зөвлөмж өгснийг 97 хувьтай хэрэгжүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

---

### 4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит

Завсрын үеийн аудитад хамрагдаагүй байна.

### 4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 67.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 22.7 сая төгрөгийн алдааг залруулж, 7.7 сая төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоож, 37.5 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

#### 4.2.1 Залруулсан алдаа

Санхүүгийн үр дүнгийн тайланд 22.7 сая төгрөгийн залруулга хийгдсэн.

#### 4.2.2 Төлбөрийн акт

##### 1.1. Илрүүлэлт:

- ✓ Бичиг хэрэг хүний нөөцийн ажилтанд нууцын зэргийн нэмэгдлийг 0.9 сая төгрөгөөр илүү, нярав, нягтлан бодогч нарт хариуцлагын нэмэгдлийг 5.4 сая төгрөгөөр үндэслэлгүй, ажилтнуудад 1.4 сая төгрөгийн илүү цагийн хөлсийг илүү тооцож олгосон.

##### 1.2. Шийдвэрлэлт:

- ✓ Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалын 4.2.3.3 заалтыг үндэслэн илүү болон үндэслэлгүй тооцож олгосон цалин хөлсийг нөхөн төлүүлэх.

#### 4.2.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй.

#### 4.2.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

##### 1.1. Илрүүлэлт:

- ✓ 37.5 сая төгрөгийн зардлын и-баримтыг бүрэн бүрдүүлээгүй

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ

хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."; гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</b>											
	Завхан аймгийн Хөгжим бүжгийн коллеж	3	67.9	1	22.7	1	7.7			1	37.5
<b>Дүн</b>		<b>3</b>	<b>67.9</b>	<b>1</b>	<b>22.7</b>	<b>1</b>	<b>7.7</b>			<b>1</b>	<b>37.5</b>

/сая төгрөгөөр/